

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ 12 ДУГААР САРЫН 15-НЫ ӨДӨР /МЯГМАР
ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

№	Хэлэлцсэн асуудал	Хуудасны дугаар
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-4
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 1.Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар 2020.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ 2.Ажлын хэсэг байгуулах тухай /“Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий/	5-30 6-27 27-30

**Монгол Улсын Их Хурлын 2020 оны намрын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 12 дугаар сарын 15-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 13 гишүүн ирж, 68.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 27 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Х.Нямбаатар, Ш.Раднаасэд;

Эмнэлгийн чөлөөтэй: Н.Учрал;

Тасалсан: С.Амарсайхан, Б.Энх-Амгалан.

Нэг.Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар 2020.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, Гадаад харилцааны яамны Консулын газрын захирал Л.Мөнхтүшиг, Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Н.Ууганбаяр, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Д.Сүнжид нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Эрх зүйн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Г.Золжаргал, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт Л.Мөнхчимэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьшаа, Ж.Сүхбаатар, Б.Энхбаяр, Н.Алтанхуяг, Ц.Мөнхцэцэг, Д.Ганбат, С.Бямбацогт нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Д.Сүнжид нар хариулж, тайлбар хийв.

Төслийн талаар Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Б.Дэлгэрсайхан, Ц.Сандаг-Очир, Н.Алтанхуяг нар үг хэлэв.

С.Бямбацогт: Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 7
Бүгд: 13
46.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын дэмжсэн санал техникийн саадлын улмаас эсрэг гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

С.Бямбацогт: Дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Үг асуудлыг 10 цаг 57 минутад хэлэлцэж дуусав.

Дэлгэрэнгүй тэмдэглэл

Нэг.Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар танилцуулна.

Д.Цогтбаатар: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Дэлхийн улсуудад аливаа шударга бус үйл явдлын эсрэг хүний эрх, эрх чөлөөг бодитойгоор эдлүүлэхийн төлөө тэмцэж буй хүний эрхийг хамгаалах чиг үйл ажиллагаа явуулах орон зай, эрх чөлөө нь хязгаарлагдаж заналхийлах, дарамт шахалтад орж буйг анхаарч Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ерөнхий ассемблей 1998 онд Хүний эрхийн хамгаалагчийн тухай тунхаглалыг батлан гаргаж, энэ чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ авахыг улс орнуудад уриалсан байгаа. Хүний эрхийн хамгаалагчийн үйл ажиллагааны баталгаа, хамгаалалтыг хууль тогтоомжоор дэмжих зорилгоор дэлхийн 40 гаруй улс хүний эрхийн хамгаалагчийн эрхийг баталгаажуулсан хууль тогтоомжийг баталсан байгаа.

Манай улсад хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаа явуулсны төлөө амь нас, бие махбодод нь халдах, заналхийлэх, дарамт шахалтад өртөх явдал цөөнгүй гарч байгаа ч хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах үйл ажиллагааг нь дэмжих эрх зүйн орчин бүрдээгүй байгаад байна. Иймд Хүний эрхийн хамгаалагчийг хуулиар анх удаа тодорхойлон, тэдний эрх зүйн байдлыг бие даасан хуулиар баталгаажуулж, хүний эрхийн хамгаалагчийн аюулгүй байдлыг хангах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх тогтолцоог байгуулах үүднээс энэхүү хуулийн төслийг боловсруулан өргөн барьж байна.

Хуулийн төслийг боловсруулахдаа хүний эрхийн төлөө олон улсын байгууллагаас гаргасан хүний эрхийн хамгаалагчийг хүлээн зөвшөөрөх, хамгаалах тухай загвар хуульд тулгуурлан Хүний эрхийн Үндэсний Комиссын хүний эрхийн хамгаалагчийн эрхийн хэрэгжилт болон Үйлдвэрчний эвлэлийн байгууллагад ажиллаж буй хүний эрхийн хамгаалагчийн үйл ажиллагааны баталгаа нэртэй судалгаа болон хүний эрхийн төлөө олон улсын байгууллагаас дэлхийн 40 гаруй улс орнуудын хууль тогтоомжид нийсэн судалгаа, НҮБ-ын тусгай илтгэгчийн зөвлөмж, НҮБ-ын хүний эрхийн дээд комиссаторын газраас хуулийн төсөлд өгсөн санал 2019 оны 9 дүгээр сарын 4-нөөс 5-ны өдрүүдэд Хүний эрхийн Үндэсний Комисс, Гадаад харилцааны яам хамтран зохион байгуулсан зөвлөлдөх уулалтад оролцсон талуудын илэрхийлсэн санал зэрэг холбогдох материалыг ашигласан болно.

Хуулийн төслийн бүтцийн талаар хэдэн зүйл хэлье. Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль нь 4 бүлэг 15 зүйлтэй. Энэхүү хууль нь хүний эрхийг хамгаалагчийн эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангахад оршино.

Хуулийн төслийн Нэгдүгээр бүлгийн нэр томьёоны хэсэгт хүний эрхийн хамгаалагч гэж хэн болох, хүний эрхийн хамгаалагчийн эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах, хүний эрхийн хамгаалагчийн эрхэд халдах үйлдлийг тусгайлан тайлбарласан байгаа. Мөн Хуулийн үндсэн зарчим хэсэгт хүний эрхэм чанарыг хүндэтгэх, ёс зүйтэй байх зарчмыг тусгаснаар аливаа этгээдийн үйл ажиллагаанд удирдлага болгох чиглэлийг хуульчилсан байгаа. Хуулийн төслийн Хоёрдугаар бүлэгт хүний эрхийн хамгаалагчийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрхийг улам өргөжүүлж, тусгайлан баталгаажуулахын зэрэгцээ үйл ажиллагаагаа явуулахдаа хориглох зүйлийг тусгайлан зааж өгсөн болно. Хуулийн төслийн Гуравдугаар бүлэгт төр, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүн байхаас үл хамааран хүний эрхийн хамгаалагчийг хүлээн зөвшөөрөх, хүндэтгэх, тэдний талаар мэдлэг, ойлголтыг түгээх, мөн төрийн тусгайлан хүлээсэн үүргийг зааж, хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн баталгааг тусгасан байгаа. Хуулийн төслийн Дөрөвдүгээр бүлэгт үндэсний хэмжээнд хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах тогтолцоог хамгийн боломжит бага зардлаар байгуулахын тулд Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах хороог Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэд байгуулахаар хуульд заасан ба гишүүд нь одоо чиг үүргээ гүйцэтгэж байгаа төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдэн ажиллахаар тусгасан байгаа.

Тус хорооны бүрэлдэхүүнд ажиллах иргэний нийгмийн байгууллагын төлөөлөлд тодорхой шалгуур тавьсан нь иргэний нийгмийг чадавхжуулах, дэмжих зорилготой бөгөөд хамтын шийдвэрээр анх удаа нэр дэвшүүлэх боломжийг бүрдүүлж өгсөн байгаа юм.

Хуулийн төсөл батлагдсанаар хүний эрхийн хамгаалагч, түүний үйл ажиллагааг тодорхойлох, иргэний нийгмийг хөхүүлэн дэмжих, хараат бус ажиллах,

эрх мэдлийн хувьд гадуурхагдсан этгээдийг хамгаалж, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлдэг хүний эрхийн түгээмэл соёл төлөвшиг нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна. Хуулийн төсөл нь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулттай харилцан уялдаатай боловсруулагдсан болно.

Хуулийн төслийг хэлэлцэж зохих шийдвэр гаргаж өгнө үү. Баярлалаа.

С.Бямбацогт: Цогтбаатар гишүүнд баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийг танилцуулъя. Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Сүнжид, Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын Хүний эрхийн хэлтсийн дарга Навчаа. Ийм хүмүүс оролцож байна.

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан төсөл санаачлагчаас асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Д.Ганбат гишүүнээр тасаллаа. Ш.Адьшаа гишүүн асуултаяа асууя.

Ш.Адьшаа: Та бүгдийн өнөөдрийн амрыг айлтгая. Энэ хуулийн төслийг дэмжиж байгаа. Зарчмын хувьд энэ хуулийн төслийг их оройтож баталж байна. Хүний эрхийг хамгаалах асуудал бол Монгол Улсад үнэхээр учир дутагдалтай байгаа. Тийм учраас энэ хуулийн төслийг нэн яаралтай баталж гаргах шаардлагатай байгаа.

Ажлын хэсгийн гишүүн Гадаад харилцааны яамны төлөөллөөс ганц хоёр зүйлийг асууя. Гадаад орнуудад ажиллаж, амьдардаг, түр оршин сууж байгаа иргэдийн эрх зөрчигдсөн тохиолдолд Гадаад харилцааны яам тухайн улсад сууж байгаа дипломат төлөөлөгчийн газраас эрх зүйн туслалцаа, тэр Монгол Улсын иргэдийн хүний эрхийг хамгаалах талаар энэ хууль, эрх зүйн хүрээнд ямар байдал байдаг вэ? Сүүлийн үед гадаадад оршин суудаг, түр ажиллаж байгаа Монгол Улсын иргэдийн эрх ашиг зөрчигдсөнд Монгол Улсын Гадаад харилцааны яам, түүнийг төлөөлж гадаад улсуудад сууж байгаа Элчин сайдын яамд хэрхэн ажилласан талаар ямар судалгаа байна вэ? Энд гадаадад байгаа иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах талаар энэ хууль тогтоомжид ямар байр суурьтай оруулсан талаар бас нэг зүйлийг асууя.

С.Бямбацогт: Хууль санаачлагч Цогтбаатар гишүүн хариульяа.

Д.Цогтбаатар: Гадаадад байгаа иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах бол Монгол Улсын гадаад харилцааны салбарын гэж ярья, бүхэлд нь, гол үндсэн зорилгуудын нэг байдаг. Тийм ч учраас Улсын Их Хурал дээр ч байнга Гадаад яамнаас энэ асуултыг асууж байдаг. Энэ нь зүй ёсны хэрэг байгаа юм. Энэ чиглэлээр манай Элчин сайдын яамдын дэргэд Консулын газрууд ажиллаж байгаа. Тэргүүн ээлжинд тэр хүмүүсийн анхаарч ажиллах хамгийн гол ажил бол энэ байдаг. Тэгээд би их энгийн жишээ, олон онолын юм ярилгүйгээр ярья л даа. Бид нар хэдхэн жилийн өмнө Чектэй, одоо Солонгостой бид нар тэнд төлсөн нийгмийн даатгалыг нь Монголд төлсөнд тооцдог болгож шилжүүлж байгаа шүү дээ. Тэнд хүн ажиллаж, ажиллаж байгаад хүнд ирээд эндээ тэтгэврээ авах боломж байхгүй байгаад байдаг, нийгмийн халамжид хамрагдах боломж байхгүй байгаад байдаг. Тэгтэл тэр боломжийг нь жишээлбэл Солонгостоо хангаж өгсөн байдаг. Бид нар Европын Холбооны гишүүн улс Чехтэй энийг хангаж өгсөн байгаа. Тэгэхэд тэнд олон мянган манай ажилчид ажиллаж байдаг. Тэдгээрийн эрх ашиг гэдэг бол үнэхээр манай анхаарлын төвд байж байдаг, хууль ёсны дагуу ажиллаж байдаг. Эргээд зөндөө олон хүмүүс очиж ажиллах боломжийг нь нээж өгч байдаг.

Энэ гэрээ байгуулагдсанаар намайг сайд байх үед, тэр ажиллаж байгаа хүмүүс энд хүрч ирээд ямар нэгэн нийгмийн халамжид хамрагдахгүй байх эрсдэлгүй, тэтгэврээ авахгүй байх эрсдэлгүй. Энэ бүх юмнуудыг нь эрх зүйн хүрээнд шийдэж өгч байгаа юм. Сая карантины үеэр л гэхэд Турк, Энэтхэг, нэлээн хэдэн манай иргэд хүнд байгаа газруудад бид нар өөрсдийнхөө боломжоор тэр НҮБ, олон улсын байгууллагуудтайгаа хамтарч байгаад бас иргэддээ хүрсэн арга хэмжээнүүдийг газар дээр нь бид нар зохион байгуулж байсан. Манай өөрийн иргэдэд туслах сангийнхаа хүрээнд ч бид нар тусалж байсан. Гэхдээ тэр бол үнэндээ бага мөнгө байдаг юм байна. Тэгтэл бид нар олон улсын байгууллагуудтай хамтраад хийж байхад энэ дээр нэлээн далайцтай ажиллах боломж гарч байсан.

Нөгөө талаасаа иргэд рүү чиглэсэн, газар дээрээ тэнд манай иргэд ямар нэгэн хуулийн асуудалд орох, ямар нэгэн байдлаар гэмт хэрэгт холбогдох, сэжиглэгдэх ийм үед нь манай консулууд байнга дуудсан үед нь л 24 цаг, 7 хоног. Бүтэн сайн, хагас сайн өдөр байхгүй шүү дээ, дуудагдсан л бол очно. Заримдаа том улсуудад бол хэдэн зуун км-ийн цаана байсан ч явж очоод төлөөлөх ажлуудаа хийж байдаг гэх мэт ийм асуудлууд байгаа.

Гадна талд ял авсан хүмүүсийн асуудал дээр бид нар хэчинээн ял аваад буруу нь тогтоогдоод явчихсан байсан ч тэнд нь манайхан очиж эргэх, наашаа шилжүүлж энд ял эдлүүлэх боломжийг нь олгох тал дээр бид нар бодитой ажил, бид нарын үед ч гэсэн хүмүүс шилжиж ирж байсан. Тэгэхээр зүгээр иргэдээр тогтохгүй, ял аваад хоригдсон байгаа иргэдээ ч бид нар мартахгүй л ажиллахыг боддог. Тэгээд Гадаад яам нэмээд хариулна биз дээ.

С.Бямбацогт: Хариулт хангалттай юу? Адьшаа гишүүн тодруулъя.

Ш.Адьшаа: Хариулсан байдал бол зөв өө. Тэнд Гадаад харилцааны яам мэдээж үүргийнхээ дагуу гадаадад сууж байгаа өөрийн төлөөллөөрөө дамжуулаад Монгол Улсынхаа иргэдийг хамгаалахын төлөө тийм ажил хийж байгаа нь тодорхой. Гэтэл яг энэ хуулийн төсөлд тэр гадаад улс орнуудад сууж байгаа Дипломат төлөөлөгчийн газрын энэ асуудал эрхэлсэн хүмүүсийн үүрэг хариуцлагыг энэ хуульдаа тодорхой зааж өгмөөр байна. Бид нар бол өнөөдрийн КОВИД-19-ийн үед л Монгол Улсын иргэд гадаадад яаж зовж зүдэрдэг, ямархуу бэрхшээл байдаг тухай тодорхой нийгэм мэдсэн. Тийм асуудлыг энд тодорхой, яг төрийн зүгээс энэ хуульд.

С.Бямбацогт: Санал хэллээ. Сүхбаатар гишүүн асуултаа асууя.

Ж.Сүхбаатар: Гишүүдийнхээ өглөөний мэндийг хүргэе. Би Цогтбаатар гишүүний энийг бас үзээд, бодоод л байгаа юм л даа. Хоёрт гэвэл хүмүүсийн хүлээлтээс бас жаахан зөрөөд байгаа юм. Тэр нь юу вэ гэхээр Шүгэл үлээгчийн тухай хууль гээд мэдээлэгч хууль бус хүний эрх зөрчсөн үйлдлийг илчлэгчийн эрхийг хамгаалах тухай асуудал их чухал байгаад байхгүй юу. Цогтоо гишүүний энэ бол, бид нар Омбудсмены нэг тогтолцооны хэлбэр болгоод Хүний эрхийн Үндэсний Комиссын хууль гаргасан. Яг энүүгээр бол, одоо Цогтоо гишүүн бол Монгол Улсын хэмжээний Омбудсмены нэг ийм тогтолцооны юмыг гаргах гэж хичээж байгаа юм болов уу гэж. Жишээлбэл, хүний эрх хамгаалагч гээд хэлэхээр хүний эрхэм чанар, олон улсын хэм хэмжээ зарчмыг хүндэтгэж хамгаалж оролцож байгаа хүнийг гэж хэлнэ. Ер нь эрхэм чанар гээд энд хүний нэр төр гэдгээ өөр маягаар бичээд байгаагаа энд бас бичиж л дээ. Энүүгээр чинь үзэхээр бүх л хүн хүний эрхийн хамгаалагч л даа. Тэгээд хэт ингээд явчихдаг. Энэ дотор нь

өргөн хүрээгээр харах юм бол хүний эрх хамгаалах тогтолцоо гэхээр хороо гээд явчихаж байгаа байхгүй юу, эргээд тогтолцоо нь.

Яг ингэж ярих юм бол нөгөө Омбудсмены юугаар бол их, дээд сургууль дотор, том үйлдвэр, аж ахуйн газар дотор, хаа ч юм бэ, олон газрууд байж болно л доо. Бид нар Хүний эрхийн Үндэсний комисс гээд эхлээд нэг тийм тогтолцоогоороо явчхаад байгаа байхгүй юу. Одоо энэ дээр ингээд харахаар яг тогтолцооны хувьд бас оновчтой байж байна уу, үгүй юу. Би маш томоор нь зохицуулах гэж оролдсон мөртлөө яг зохицуулалттай байж чадаж байна уу гэдэгт л би эргэлзээд, уншихаар, бодохоор. Энэ урьд нь, өнгөрсөн жил би Их Хурлын даргын ахлах зөвлөх байхад Шүгэл үлээгчийн хууль ярьж байхад Л.Болд, Цогтбаатар гишүүдийн энэ юмыг хараад байгаа юм л даа. Тэгээд, хумихгүй болохоор Хүний эрхийн Үндэсний комисс бас юу гэж бодож байгаа юм бол. Хүний эрхийн Үндэсний комиссын дэргэд хороо ажиллана гэж байгаа юм. 7 хүний бүрэлдэхүүнтэй. Энэ одоо яг аль загвар юм бэ? Омбудсмены юмыг л хэлж байх шиг байна. Би бол шүгэл үлээгч дээр мэдээлэл илчлэгч тэр хүний юмыг, уг нь тэр рүү нь явсан бол илүү.

Одоо энэ чинь энд харвал өр нь яг хүний эрх хамгаалагч гэчхээд байгаа байхгүй юу. Тэгээд энийг одоо мэдээж хэлэлцэх эсэхийг нь дэмжлээ гэж бodoход яаралтай баталж болохгүй энэ бол. Харин ч олон нийтийн хэлэлцүүлэг, хэвлэл мэдээлэл, хүний эрхийн, Их Хурлын даргын яриад байгаа law forum, legal matter гэнэ үү, тэр сайтууд бий болгоно гээд байгаа саналыг нь авч, харин энэ Их Хурлын бүр чухал ажил болгох ёстой. Цогтоо гишүүний энэ талаас нь би чухал гэж үзэж байна. Харин яаралтай батлах юм бол, нэг ийм яаралтайгаар батлагдсан даржуу хууль болчихно гэж давхар саналаа хэлэхэд ийм байгаа юм.

Тэгээд Цогтоо гишүүнд хэлэхэд энэ яг юу байна вэ, Омбудсменыг бухэлд нь гээд. Энэ тодорхойлолтыг ч харсан, өөрсдөө үз дээ. Бүх л хүн хүний эрхийн хамгаалагч. Ер нь бол зарчмын хувьд, мөн чанарын хувьд бол тийм л байх л даа. Гэхдээ энэ чинь хамгаалах тогтолцоо, хүний эрх хамгаалагчийн эрх гээд явчихаар чинь ингээд, бүх хүн чинь ийм байж болохгүй шүү дээ. Тэгээд хороонд үүрэг өгч байгаа бол энэ хороо чинь Хүний эрхийн Үндэсний Комиссоос манлайлуулсан Омбудсмены юм байх юм бол энэ хороо чинь ерөнхийдөө бүх шатанд л зүгээр л ажиллана гээд ингээчихсэн ийм л цомхон юм байгаад байна. Би энд шүүмжлэлтэй талаас нь зүгээр асууж байгаа юм. Тэрнээс дэмжихгүй гэж байгаадаа биш. Энэ бол яарч даарч болохгүй юм байна лээ шүү. Энэ нэр томьёг нь харсан ч их том, зохицуулалт нь өргөн. Яг байгаа онох нь уу, үгүй юу.

С.Бямбацогт: Цогтбаатар гишүүн, хууль санаачлагч хариулья.

Д.Цогтбаатар: Сүхбаатар гишүүний асуултад хариулья. Зүй ёсны асуулт тавьж байгаа юм. Яагаад гэвэл шүгэл үлээгчтэй байнга андуурч байгаа юм. Би ч гэсэн өөрөө Хүний эрхийн дэд хорооны дарга байхад таны ярьж байгаа наад функциг чинь хийж байгаа Хүний эрхийн Үндэсний Комисс өөрөө энэ хуулийнхаа төслийг барьж ирээд, гишүүн ээ, энийг оруулахгүй бол үнэхээр болохгүй байна, Хүний эрхийн дэд хороо хариуцаж байгаа хүний хувьд та энэ дээр ажиллаж өгөөч ээ гээд. Би тэгэхэд эхлээд яг тэгж хүлээж авч байсан. Энд чинь шүгэл үлээгчийн асуудал гарч ирж байгаа юм биш үү, Хүний эрхийн Үндэсний Комисс өөрөө энэ ажлыг хийх ёстой биш үү, давхцаад байгаа биш үү гэдэг асуудлыг ярьж байсан. Нэлээн шалгуур, судалсны дараа энийг оруулах нь зөв юм байна гэж харсан. НҮБ-ын үндсэн дүрмийн 10.3 дээр НҮБ бол олон улсын хуулийг хөгжүүлэн боловсруулж байх үүрэгтэй байдаг. Тэгээд НҮБ-ын Ерөнхий

ассамблейгаас яг энэ чиглэлээр ийм хуулиудыг гаргаач ээ гэдэг тунхаглалаа гаргаж өгөөд, загвар хуулиа баталж өгөөд, энэ дээр 40-өөд орон энэ хуулийг баталчихсан байгаад байгаа юм.

Шүгэл үлээгч гэдэг бол ямар ч асуудлаар, хэн ч байж болно. Энэ дээр бол бүр хуулийн төсөл дээр их тодорхой заагаад өгчихсөн байж байгаа. Хэнийг жишээлбэл, энэ хороондоо оруулах вэ гэхээр ийм, ийм шалгуураар, 7-гоос доошгүй жил яг хүний эрхийн асуудлаар ажилласан, түүнээс өөр хaa хамаагүй асуудлаар ажиллаж, ажиллаж байгаад би энд орж ирнэ гэж тавиагүй. Өөрөөр хэлбэл энд, би төрийн албанад олон ч жил ажиллаж байна, би чадна гэдэг хүмүүс их, би тийм ч юманд гээд, шал хамаагүй юманд ажиллаж байснаа төрийн ажлын туршлагатай гээд л ярьдаг. Энд бол яг мэргэжлээр нь ингэж, ингэж ажилласан хүнийг оруулж ирнэ гээд зааж байгаа юм.

Өөр нэг зүйлийг би хэлмээр байгаа юм. Энэ хүний эрхтэй холбогдолтой. Бид ардчилсан орон, хүний эрхийн институцууд бүрдчихсэн болохоор яг ингээд сэтгэл ханачихсан байгаа юм, манай оронд бол хүний эрхийн асуудал байхгүй шүү дээ гээд. Энд сууж байгаа бид нар бүгдээрээ мэдэж байгаа. Яг одоо хүний эрх зөрчигдөөд л явж байгаа. Тэгээд энэ дээр чинь яг бодит байдал дээрээ хүний эрхийг хамгаалдаг хүний тоо цөөхөн юм байна лээ шүү. 4-өөс 5 хүнийг чимээгүй болгоход цаана нь 1 сая чимээгүй болох юм байна лээ. Харахад хүний эрхийн бүх институтцууд чинь байна. Хуулийн давж болохгүй босгүүрдүүг нүдээ анъиж байгаад, дарга хэлсэн юм гээд даваад л байна. Хуулийн давж болохгүй босгыг давах тоолонд нэг хүний эрх зөрчигдэж байгаа. Нийт эрх нь зөрчигдэж байгаа нэг сэхээтний цаана хэдэн мяанган энгийн иргэн зүгээр чимээгүй зөрчигдөөд явж байгаа гэсэн үг. Хамгийн дуу шуутайнуудын эрхийг зөрчөөд байхад чимээгүй байгаа бол цаана нь бүр чимээгүй байна гэсэн үг. Тэгэхээр бид нар сэтгэл ханаж болох юм уу?

Өнөөдөр олон улсын энэ хүний эрхийн тусгай илтгэгч, Европын Аюулгүй байдал, Хамтын Ажиллагааны байгууллагаас гаргасан зөвлөмж, НҮБ-аас гаргаж байгаа бүх зөвлөмжид Монголын шүүх, хууль хэрэгжүүлэх байгууллагуудын хараат бус байдал бол хүнд байдалд байна, энэний ард хүний эрх зөрчигдөх хамгийн өндөр магадлал байна гээд бүх газар ингээд бичдэг болчихсон шүү. Бид нар эндээ болохоор бүх юм болчихсон гэж бodoод байгаа. Огт болоогүй байгаа шүү. Хүний эрх зөрчигдэж байгаа бол ардчилал байхгүй гэсэн үг. Ардчилал бүх юман дээрээ бичээстэй байж болно. Хамгийн ардчилалгүй улс өөрийгөө ардчилсан гээд нэрлэчихсэн ч юмнууд байж байгаа юм. Тэгэхээр ардчилал байна гэдгээр хүний эрх хангагдаж байгаа биш шүү. Энэ дээр нь тусгайлсан хүн гаргаж өгөх ёстой гэж бодож байгаа. Тэгээд Хүний эрхийн Үндэсний Комисс энэ дээр бас та саналаа хэлэх нь зөв байх аа гэж бодож байна.

С.Бямбацогт: Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Сүнжид. Энэ бас анхаарах асуудал л даа. Хүний эрхийн Үндэсний Комисстoy давхацсан чиг үүрэгтэй, эрхээ булаацалдсан ийм байгууллага болчих юм биш байгаа гэсэн болгоомжлол бас байгаад байна. Сүнжид хариулъя. 1 номерын микрофон.

Д.Сүнжид: Та бүхэнд энэ өглөөний мэндийг хүргэе. Хүний эрх хамгаалгачийн эрх зүйн байдлын тухай хуулийг боловсруулсан түүхийг нь харахаар 2014 оноос эхэлж хэлэлцээд, 2016 онд судалгаа аваад Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Хүний эрхийн Үндэсний Комисстoy хамтраад 2018 оноос идэвхийлээд Хүний эрхийн Үндэсний Комиссын өмнөх гишүүд ажлын хэсэг байгуулаад явж байсан түүхтэй. Энэ яагаад энэ хууль хэрэгтэй вэ гэхээр бид нар

Хууль тогтоомжийн тухай хуулиараа хэрвээ одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа аливаа нэг хуулиар зохицуулж болж байгаа бол давхардуулж болохгүй. Зохицуулаагүй шинэ харилцаа орж ирж байгаа бол шинэ хуулийн төслөөр өргөн барьж ингэж батлах зохицуулах учиртай.

Энэ утгаараа хэрвээ хүний субъектив эрх зөрчигдөх юм бол түүнийгээ өөрөө хамгаалах, нэхэмжлэлээр хамгаалах, хуульчаар хамгаалуулах эрх нь байна. Эрүүгийн хууль, Эрүүгийн процесс, Иргэний хууль, Иргэний процесс, Захиргаа процесс гээд байна. Өөрөөр хэлбэл, субъектив эрхийг хамгаалах орчинг бид нар хууль тогтоомжоороо өөрийн механизмыг бүрдүүлжээ. Тэгвэл өөрийн биш, нийтийн ашиг сонирхолд хамаатай бусдын, бүлгийн эрх зөрчигдвэл ямар хуулийн дагуу түүнийг хамгаалах вэ гэдэг асуудал энд учир дутагдалтай байна, тэрийг энэ механизмыг илүү сайжруулах ёстой байна гэдэг ийм судалгаа, шинжилгээний дүгнэлтийг үндэслээд, тухайлбал ялангуяа эрх нь зөрчигддөг мөртлөө түүнийгээ өөрсдөө илэрхийлэх, хамгаалах боломжгүй бүлгүүд байдаг, нийгэмд. Тээврийн жолооч нарын асуудал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал, туслах малчны асуудал гээд үргэлжилнэ. Өөрөөр хэлбэл, тэр хүмүүс өөрсдийнхөө өмнөөс энэ бол миний эрхийн зөрчил юм гээд, түүнийгээ нэхэмжлэн хамгаалах, шаардлага гаргах, гомдол гаргах боломжгүй байдалтай тийм бүлгийн эрхийг хамгаалахад энэ хууль туслах учиртай гэж харж байна.

Гол асуудал нь Хүний эрхийн Үндэсний Комиссын мандат, бүрэн эрхтэй хэр нийцэж байгаа вэ гэж. Тэгэхээр комиссын зүгээс бодлогын хэмжээнд зөвлөмж өгөх, хуулийн төсөлд санал өгөх байдлаар уулзах бүрэн эрхтэй байгаа. Түүнээс гадна тодорхой хяналт шалгалт хийх, гол мэдээллийг хүлээн авах эрхтэй байгаа. Энэ дунд аль нэг бүлгийн эрх, аль нэг хэсэг газар оршин суугчдын эрх зөрчигдөж байгаа аваас тэнд нь энэ хүний эрхийн хамгаалагчид анхааруулга өгч байх ёстой, судалгаа шинжилгээ хийж байх ёстой, хамтарч дуу хоолойгоо илэрхийлээд зохих төрийн байгууллагуудад нь уламжлаад шийдүүлэх ийм чиг үүргийг хүлээх юм. Тэгэхээр энэ дээр чиг үүргийн давхцал биш, хамтрах, нэг нэгийнхээ орон зайг нөхөөд хүний эрхийг хамгаалахад энэ механизмыг ажиллуулахад энэ тогтолцоо учиртай гэж ингэж бодож байгаа.

Хуулийн төслийг үр нөлөөний үнэлгээн дээр бас энийгээ хэлсэн. Өөр байдлаар зохицуулах боломжтой юм уу гэж. Тэгэхээр Хууль тогтоомжийн тухай хууль, түүнийг дагаад гарсан Засгийн газрын тогтоол байгаа, 59 дүгээр. Тэрний дагуу хийсэн судалгаагаар үр нөлөөний үнэлгээгээр Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс бие даасан хуулийг баталсан нь энэ хүний эрхийг хамгаалахад хамгийн их ач холбогдолтой, зорилгодоо хүрэхээр байна гэдэг дүгнэлтийг өгсөн байгаа. Захиргааны аргаар шийдвэрлэх, одоо юу ч хийхгүй байх, эсхүл байгаа бусад хуулиуддаа нэмэлт, өөрчлөлт хийх замаар шийдэх хувилбараас илүү, бие даасан хуулийг батлах нь зөв юм байна, зорилгодоо хүрэх юм байна, ач холбогдолтой юм байна гэдэг ийм дүгнэлтийг өгсөн байгаа.

С.Бямбацогт: Сүхбаатар гишүүн тодруульяа.

Ж.Сүхбаатар: Олон юм байна, энэ зааг ялгаа өгөхгүй бол тодорхой харагдаж өгөхгүй байна. Түрүүн хуралдаан даргалагч бас хэллээ шүү дээ. Хороо бол мэдээлэл, гомдлын дагуу эрх бүхий шилжүүлэн бичгээр хариу нийцлийн үнэлгээ, хүний эрхийн хамгаалагчийн үндэс, дүгнэлт гаргах чиг үүргийг хэрэгжүүлнэ гэж байгаа юм. Гол чиг үүрэг нь. Тэгээд хорооны дарга нь Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн байна гэж байна, хорооны үйл ажиллагааны санхүүжилтийг комиссын төсөвт тусгана гэж байгаа юм.

Одоо хорооны гишүүдээс чинь нэг нь ийм хорооны дарга хийгээд, тэгээд хорооны дэргэд энэ ажиллана гэж байгаа юм. Тэгэхээр энийгээ бодоорой. Энэ чинь хийж байгаа ажил нь бол Үндэсний комисстай л холбоотой ажил юм. Комисст дэмжлэг үзүүлэх гэж ойлгож болж байна. Гэхдээ уг нь манайд ер нь ийм асуудал байгаа юм. Омбудсмены тогтолцоог, Монгол Улсын Их Сургууль гэхэд, бусад сургуулиудыг би яриад яахав. Бүгд байна, адилхан жишээ гэж бодож болно. Тэгэхэд энэ олон мянган оюутантай газар Монгол Улсын Их Сургуульд нэг омбудсмен байх шаардлага байгаа байхгүй юу, бусад Скандинавын орнуудтай адилхан, тэгээд Австрали эд нартай.

С.Бямбаатар: Сүхбаатар гишүүнд 1 минут.

Ж.Сүхбаатар: Энэ мэтийн асуудлаа анхаарах асуудлууд манайд байсан юм. Одоо ингээд харахаар ямар асуудал болж байна вэ гэхээр ер нь манайд Үйлдвэрчний эвлэлийн тухай хууль одоо шинэчлэгдээгүй явж байгаа. Үйлдвэрчний эвлэл бас, халих юм бол хуучин гишүүн байсан Ганбаатарынхаар бол бүр яг энэ хэмжээний ажил хийх гэж оролддог болсон. Энэ хууль гараад ирнэ. Тэгэхээр бас Үйлдвэрчний эвлэл бас хүний эрхийг хамгаалах бас нэг том тогтолцоо болж өөрсдийгөө үздэг, ярьдаг. Энэ асуудал тодорхойгүй байгаа. Энэ хороонд жишээлбэл энэ төлөөлөл байхгүй байна гэх мэтийн ер нь олон бүрхэг асуудлууд байна. Энэ бол том загвар бий болох ёстой асуудал болж байгаа юм. Хүний эрхийн Үндэсний Комисс өнгө төрхөө тодорхой олж амжаагүй явж байгаа. Тэгэхээр энийгээ их сайн яахын тулд ажлын хэсэг гаргаад, тэгээд маш сайн хэлэлцүүлэг удаан хугацаанд хийх ёстой юм байна шүү гэж л би хэлэх гээд байгаа юм. Яарч сандраад нэр хүнд олоод нэг их сайхан ажил хийсэн биш, олон нийтийн оролцоотой, тэгээд холбогдох газруудыг судлаад, НҮБ-ын тэр юмыг Монголын хөрсөн дээр зөв ургуулж.

С.Бямбаатарт: Ерөнхийдөө санал хэллээ. Энхбаяр гишүүн асуултаа асууя.

Б.Энхбаяр: Баярлалаа. Яг асуух гэж байсан зүйл сая Сүхбаатар гишүүн асуугаад, бас хариулт авчихлаа. Ер нь гол асуудал бол дөнгөж сая шинээр байгуулсан Хүний эрхийн Комиссын чиг үүрэг юман дээр давхцаад бас саад болчих вий. Дэмжигч, хамтрагч гэдэг үгийг сая хэлж байна. Тэр статус их товоож гарах ёстой шүү гэдэг ийм бодол сая асуулт, хариултыг явцад бодогдож байлаа.

Ер нь Монголын төр ялангуяа хууль тогтоомж, хүний эрхийн асуудал дээр бол нэг нүүртэй баймаар байгаа юм. Тэгээд нэг нүүртэй гэдэг бол нэг бодлоготой, тогтвортой байх тухай асуудал л даа. Манай Үндсэн хуулийн цэцийн анхны дарга гавьяат хуульч Совд гуай нэг ийм үг хэлсэн байдаг юм, хүн төрөлхтний түүх бол ерөөсөө хүний эрхийн төлөөх тэмцлийн түүх юм гэж. Энэ хэзээ ч дуусахгүй. Хүний эрхийн төлөөх тэмцэл гэдэг бол өөрөө урагшлуулж явж байдаг. Тэгээд энэ агуулгаар бол бид өнөөдөр сэтгэл ханах байтугай маш их олон асуудал байна.

Гуравхан жилийн өмнө Эрүүгийн хууль тогтоомж хүчин төгөлдөр болоод л, бид нар иргэдийнхээ үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрхийг шоронд хийхгүй гэдэг хууль гаргачихсан шүү дээ. Хэзээ ч итгэл үнэмшил, үзэл бодлыг шоронд хийхгүй. Хорих ялыг энэ худал мэдээлэл тараах, гүтгэх гэмт хэргээс аваад хаячихсан. Энэ бодлого дээрээ манай Улсын Их Хурал, тэр дотроо тухайн үед энэ шийдвэр гаргаж байсан Ардчилсан нам ч бай, Ардын нам ч бай, би бол хамт байгаа гэж ойлгож байгаа юм. Энэ бол их чухал асуудал.

Хүний итгэл үнэмшил гэдгийн цаана хүний мэдэх эрх яваад байгаа юм, иргэдийн төрөө хянах эрх яваад байгаа юм, итгэл үнэмшилтэй байх эрх яваад байгаа юм. Миний хувьд 2017 оны зун НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл дээр манай улсын иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактын хэрэгжилтийн тайланг бас хамгаалж тайлагнаж байсан. Энэ асуудал дээр НҮБ-ын Олон улсын хамтын нийгэмлэг бол сайшаасан шүү дээ. Та нар шоронд л хийж болохгүй шүү энэ үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хэрэгжүүлснийх нь төлөө. Тэгээд одоо ингээд манай сайд маань хууль санаачлаад бас л бужигнуулаад л байгаа юм. Энэ бол би эрх барьж байгаа Монгол Ардын намын бодлого биш ээ гэж харж байгаа юм. Тэр дотроо Улсын Их Хурал, Хууль зүйн байнгын хорооны бодлого бол биш. Эрх барьж байгаа Монгол Ардын намын бодлого биш. Хувьдаа бол ийм төсөл орж ирэхэд хэзээ ч дэмжихгүй. Ийм, олон түмний үймүүлж, иргэдийн мэдэх эрхийг хязгаарлах гэсэн ийм санаархлыг одоо болимоор байна. Ер нь ийм юм боддогийг авч хаямаар байна.

Нэг гараараа Хүний эрхийн комиссоо байгуулаад л хүний эрхийн төлөө тэмцэж байна гээд одоо ингээд ярьж байдаг. Нөгөө гараараа хамгийн суурь хүний эрхүүдийг широнжуулах тухай ингээд яриад суугаад байдаг байж таarahгүй гэдэг ийм бодлтой байгаа юм. Энэ нэг бодлого, нэг нүүр, зарчим юман дээрээ байх ёстой шүү.

Тэгээд Цогтбаатар гишүүндээ бас баярлалаа. Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдал. Энэ анх удаа бас орж ирж байгаа юм. Би энэ доторхыг нь, агуулгыг нь харахаар бас яг комиссын хуулиас өөр байна. Энэ ерөөсөө бүхнийг хүний эрхийг хамгаалагч уу гэдэг, татан оруулах гэж байна. Энэ ганцхан төрийн ажил биш, энэ нэг байгууллагын ажил биш. Ерөөсөө бид бүгд хүний эрхийн хамгаалагч болох тухай.

С.Бямбацогт: Санал хэллээ. Алтанхуяг гишүүн.

Н.Алтанхуяг: Энэ хуулийг би сая нэг гүйлгээд харлаа. Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай. Уг нь санаа нь зөв л юм. Хүний эрхийн комисс гээд баахан хүнийг манайхан сүр болгож, баахан шалгаруулаад, сар ажиллаж байна уу, хоёр сар ажиллаж байна уу? Тэгээд л бахь байдгаараа таг дуугүй. Энэ дотор бас баахан хороо байгуулаад л. Манайхан юм болохоор л нэг юм байгуулаад дарга, цэрэг л болох юм ярих юм. Хүний эрхийг дарга, цэрэг болж байж хамгаалахгүй ээ. Байр байран дээрээ олигтойхон шиг дуугарч байж, үзэлцэж байж хамгаална. Хүний эрхийг хамгаалаад өг гээд хэдэн амьтан хороо байгуулаад явна гэж юу ч байсан юм. Би агуулгаар нь дэмжиж байгаа мөртлөө хэлбэрээрээ бол энэ бид нарын хэдэн сарын өмнө хийсэн ажлыг будаа болгоно.

Ер нь манайхан ингэдэг шүү дээ, бараг Монголын нууц товчооноос эхэлсэн байх. Тэнгэрт хоёр нар байдаггүй л гэдэг юм. Энэ одоо дахиад тэнд очоод тийм л юм болно. Танайхан тэгнэ, манайхан гээд. Одоо болиоч ээ, энийгээ зогсоо. Би таныг хууль санаачилснаар нь тэгж байгаа юм биш шүү. Энэ чинь давхардал үүсгэж байгаа юм. Харин хүний эрх хаана зөрчигдэж байна гээч. Хүний эрхийг хамгаалагчид олноороо гарч ирнэ. Хүний эрх хаана зөрчигдэж байгаа вэ? Хамгийн номер 1 бол Монголд хууль хяналтын байгууллагууд дээр зөрчигдэж байгаа. Дарга нар нь дээрээс нь үгэнд ор, үгэнд орохгүй бол шоронд орно гэж хэлдэг. Тэгээд доод талынх нь хүмүүс нь хор-оороо тэрийг гүйцэтгэдэг.

Би бол харин ингэж хүний эрхийг зөрчсөн хүмүүсийг шийтгэх тэр шийтгэл бол манайд байхгүй. Тийм учраас одоо арав гаруй

хүнийг хэлмэгдүүлчихсэн байцаагч өнөөдөр АТГ дотроо сууж л байгаа юм. Тэгээд би энэ нөхөр ямар юм хийдэг юм бэ гэсэн, энэ нөхөр арай өөр сайхан ажил хийж байгаа гэж байгаа юм. Ийм байдалтай байх юм бол Монголд хүний эрх яриад хэрэггүй. Хүний эрхийг зөрчсөн хүмүүсийг шийтгэдэг тэр шийтгэврийн хуулийг бид нар харин янзалмаар байна. Би энэний дараа орох асуудал байгаа шүү дээ, Хууль дүрмийг боловсронгуй болгох. Би ажлын хэсэгт орьё гээд гарaa өргөсөн байгаа шүү. Би ийм зорилготой орох гэж байгаа юм. Яахаараа ингээд байдаг юм бэ?

Төр одоо ингээд, тэнд байгаа нэг түшмэл дээд талынхаа даргаас авч өчинөөн олон хүнийг хэлмэгдүүлчхээд оронд нь хүний жаахан охиныг зургаан сар шоронд суулгачхаад, тэгээд төрөөс 45 сая төгрөг гаргаж өгөөд л, тэгээд дуусаа. Тэр хүн дээр ямар хариуцлага очиж байгаа юм бэ? Тэрний хойноос хэн хөөцөлдөх юм бэ? Чааваас шоронд орсон хүүхэд дахиад тэнд хэрэг үүсгүүлэх гээд гүйх юм уу? Энийг харин хамгаалах асуудал бол хүний эрхийг хамгаалах асуудал. Тэрний өмнөөс төр ажиллах ёстой, тэр прокурор ажиллах ёстой. Энэ чинь факт нь байна шүү дээ. Төр энэ хүнийг хэлмэгдүүлсэн гээд мөнгөө гаргаад өгчхөөд байхад яахаараа тэр тамлаж баахан зовоосон хүн нь хариуцлагагүй хүлээхгүй байгаа юм бэ?

Би энэ чиглэлийн хууль тогтоомж боловсронгуй болгох дээр, гэхдээ дахиад бас туйлшуулаад хэн нэгэн хууль хяналтын хүнийг хэлмэгдүүлчих агуулгаар биш, хариуцлагатай байх агуулгаар энэ хуулийн төслүүд дээр ажиллаж гэж байгаа юм. Тийм учраас би та бүхэнд хүний эрхийг хамгаалах тал дээр хангалттай юмнууд явж байгаа. Ажлаа хий л дээ. Хүний эрхийн комисс танайх ажлаа хий л дээ. Би Хүний эрхийн дэд хороонд бас гарaa өргөж байгаад орсон. Одоо жаахан дорвитой юм хиймээр байна. Ийм үлгэн салган, нэг байгууллага байгуулаад, Үндэсний хороо байгуулаад. Тэгээд хэдэн зориг зүрхгүй юмнууд нь ингээд ямар хэрэг байгаа юм бэ? Сая КОВИД гээд эд нарт нэлээн гомдол хүсэлт очсон байна лээ. Хийж байгаа юм байхгүй байна. Ажлаа хий, байгууллага тэр ярьдаг.

С.Бямбацогт: Цогтбаатар гишүүн

Д.Цогтбаатар: Алтанхуяг гишүүн асуудлын гол юмыг нь яриад, тэр хүний эрхийн асуудал чинь байгаад байна. Тэгээд та яагаад ажлаа хийхгүй байгаа юм бэ гээд Хүний эрхийн комисс руу хараад хэлж байна. Би танд хариулаад өгье. Тэр хамгаалалт чинь байхгүй байгаа юм. Наадуулыг чинь хүний эрхийн асуудалтай холбогдсон янз бүрийн юм яриад ирвэл өөрсдийг нь барьж аваачаад янз бүр болох. Одоо энэ хууль дээр, бид нар энэ дээр суучхаад энэ болгоныг анзаарахгүй. Наадуул чинь амьдрал дээр тэр зовлонтой тулж байгаа учраас өөрсдөө барьж орж ирж байгаа байхгүй юу. Ямар ч хамгаалалт байхгүй. Тэгсэн мөртлөө бид нар эндээс та нар ажиллаад өгөөч.

Хүний эрхийн хамгаалалт гэдэг чинь шинэ эрх зүйн институц болж тусгайлан заагдаж орж ирж байгаа юм. Хүний эрхийн хамгаалагчийг хамгаална гэдэг яг институтчилэгдсэн ойлголт өнөөдөр нарийвчлан боловсруулагдаж орж ирээгүй байгаа. Энэ хүмүүсийг чинь хамгаалж байж тэр хүний эрх чинь хамгаалагдана. Олон юман дээр манайхан наад Хүний эрхийн комисст ч, энэ Их хурал дотор ч зөндөө хүн яримаар юман дээрээ дуугүй л байгаа. Яагаад гэвэл тэгж ярихад нь эргээд хариуцлага тооцох тэр эрсдэл байгаад байгаа учраас тэгж байгаа юм.

Одоо ингээд Хүний эрхийн комисс дээр та нар энийгээ хийнэ шүү дээ гэхэд яг амьдрал дээрээ аягүй олон завсардал, саарал орон зай гарад байгаа

боловхоор нөхөх гэж наад хүмүүс чинь оруулж ирж байгаа юм. Тэгээд яг Хүний эрхийн комисстойгоо энэ юмаа нэгтгэж явуулахын тулд энэ дээр хороо байгаад ингэж явах нь дээр байна гээд хамгийн бага төсвийн зардалтайгаар, гэхдээ хамгийн том үр дүн өгөх энэ хувилбарыг сонгоод л оруулж ирж байгаа юм.

С.Бямбацогт: Баярлалаа. Мөнхцэцэг гишүүн асуултаяас асууяа.

Ц.Мөнхцэцэг: Хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байна. Хүний эрхийн дэд хорооны гишүүний хувьд би Монгол Улсад хүний эрхийн зөрчил байсаар байна. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, тусгай хэрэгцээтэй иргэд нийгэмд ажиллаж, хөдөлмөрлөх, нийгмийн бусад гишүүдтэй нэгэн адил нийгэмдээ ажиллаад, амьдраад чадвар боломжоо гаргах боломж өнөөдрийг хүртэл хомс байна. Тэгээд эмэгтэйчүүд, хүүхдүүд, мөн тодорхой цөөн тооны ч гэсэн эрэгтэйчүүдийн хүчирхийллийн золиос бол байсаар байна. Улс төрийн намаар ялгаварлан гадуурхдаг, улс төрийн намын харьяаллаар дамжуулаад төрийн үйлчилгээ, хороон дахь хороо, баг нийгмийн үйлчилгээг ялгаварлаж өгдөг, шашин шүтлэг, үзэл бодол, нийгмийн байдлаар ялгаварладаг ийм байдал байсаар байна. Сүүлийн хэдэн жил цахим орчинд хүний эрхийн зөрчил тод харагдаж байна. Цахим гадуурхал, доромжлол байгаад байна.

Тийм учраас бид нар Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоогоо бүхий л байдлаар дэмжих ёстай. Тэгээд энэ Хүний эрхийг хамгаалах хууль бол олон улсын хүний эрхийн тогтолцооны бас нэг чухал хэсэг, ингээд Монголд нэвтрүүлж байгаа ийм зүйл. 1948 оны Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 50 жилийн ойгоор буюу 1998 онд Олон улсын хүний эрхийн хамгаалагчийн тунхаглал гэдэг баримт бичиг гарсан байгаа. Тэрэнд төрийн үүргийг, тэр дотроо хүний эрхийг хамгаалагчийг хамгаалах, дайралт, ялгаварлан гадуурхалт, мөн хууль сахиулах байгууллагуудын юунаас хамгаалах энэ тухай бараг 10 гаруй ийм үүргийг хүлээлгэсэн байна. Тунхаглалын 2, 9, 12, 14 дүгээр зүйлд. Энэ дотор хүний эрхийг хамгаалах чиглэлээр ажилладаг байгууллагууд, үндэсний тогтолцоо, түрүүн Сүхбаатар гишүүн хэлсэн Омбудсмены тогтолцоо.

Манайд бол Хүний эрхийн Үндэсний Комисс байгаа. Үүний хажуугаар бусад төрийн бус байгууллага сүлжээг дэмжих ёстай гэсэн төрийн үүргийг хүлээлгэсэн байна. Тэгээд миний хувьд Монголд хүний эрхийн зөрчил, хүний эрхийн мэдрэмжийг түгээн дэлгэрүүлэх, нийгмийг гэгээрүүлэх энэ чиглэлийн ажил бол маш их хомсдолтой явагддаг. Тийм учраас дахиад хүний эрхийг хамгаалах байгууллага бол илүүдэхгүй, энийг байгуулах ёстай гэж үзэж байна.

Хууль санаачлагчаас ийм асуулт байна. Хүний эрхийн хамгаалагчийн хороо гэж байгууллагдана. Энэ хорооны үйл ажиллагаа маань ямаршуу статусаар явагдах вэ? Бусад төрийн бус байгууллагууд, Хүний эрхийн Үндэсний Комисс, мөн хууль сахиулах байгууллагуудтай яаж ажиллах юм бэ? Зөвлөмж өгөх юм уу, шаардлага өгөх юм уу? Ер нь хорооны үйл ажиллагааг ямар журмаар зохицуулах вэ гэсэн асуулт байна.

С.Бямбацогт: Цогтбаатар гишүүн хариульяа.

Д.Цогтбаатар: Мөнхцэцэг гишүүнд баярлалаа. Энэ асуулт бас яг яаж ажиллах вэ гэдэг үнэхээр чухал. Хороо бол өөрөө хүний эрхийг Монгол Улсад байгаа хамгаалагчдын үйл ажиллагааг бүхэлд нь зохицуулж уялдуулж явах юм. Хамгийн гол нь энэ хороон дээр ямар асуудал тавигдах вэ гэхээр нэгдүгээр зорилго нь хүний эрхийг хамгаалагч хүмүүсийг, тэдний ар гэр. Одоо хүний эрх хамгаалаад явж байгаа хүмүүст учирч байгаа эрсдэл чинь зөвхөн өөрт нь биш

байхгүй юу. Ар гэр, шууд хамтран амьдрагч эд нарт нь нөлөөлөөд өхлэхэд л хүн чимээгүй болчихож байгаа юм. Тэгэхээр тэрэн дээр нь шууд хуулийн хамгаалалт нэр заагаад орж өгнө гэдэг чинь тэр хуулиуд, энэ хууль хэр хэрэгжиж байна вэ, хэр зөрчигдөөд байна вэ, хаана тэр хүний эрхийг хамгаалаад явж байгаа, зүгээр дурын хүн биш шүү дээ энэ чинь.

Хүний эрхийг олон жил хамгаалаад, хүний эрхийг хамгаалагч гэдэг нь тодорхой болчихсон энэ хүмүүсийг яаж эрхийг нь зөрчөөд байна вэ, тэр хамгаалалтыг яаж зөрчөөд байна вэ гэдгийг л энд тодорхой зааж өгөөд, энэний хэрэгжилтийг хангaad явах 7 гишүүн. Тийм учраас энэ 7 гишүүнд чинь Өмгөөлөгчдийн холбооноос, төрийн бус байгууллагуудаас, Хүний эрхийн комиссоосоо ч гэсэн ингээд ороод явчихсан байж байгаа юм. Тэрний хажуугаар сая Сүнжид докторын хэлээд байгаа Хүний эрхийн комисс гээд нэг том байгууллага, хариуцаж байгаа асуудлууд нь нэг талдаа. Төрийн бус байгууллагудын хариуцаж байгаа асуудал нь нэг талдаа. Энэ завсар аягүй том саарал орон зайд байж байгаа юм. Энэ дээр хүний эрх бол өнөөдөр өдөр болгон зөрчигдөөд явж байгаа. Тэгээд тэр анзарагдахгүй байгаа юм. Тэрийг анзаардаг энэ механизм өөрөө бий болж өгч байгаа юм. Тэгэхээр энэ дээрээ бол, одоо энд түрүүн Энхбаяр гишүүн яг зөв юм хэлж байгаа юм.

Энд хүний эрхийг бүгд хамгаалах үүрэгтэй. Одоо энд бол бүр аж ахуйн нэгж, байгууллагууд ч гэсэн. Яагаад гэвэл хөдөлмөрийн гэрээгээ яриад л давхиад ороход тэнд зөрчлүүд амьдрал дээрээ маш их гарч байдаг. Тэгэхээр энэ бүгд дээр учлаарай, аж ахуйн нэгж, байгууллага та бас хүний эрхийг хамгаалах ёстой шүү. Энэ хөдөлмөрийн эрх, эдийн засгийн эрх, боловсрол олох энэ юмнууд дээр сургууль, бусад байгууллагууд бүгд оролцож байгаа, үүрэг хүлээж оролцож байгаа шүү. Тэгээд энэ хуулийн яг хэрэгжилтийг нь амьдрал дээр нь хянаж, хангаж байх энэ байгууллага нь хороо байгаа юм.

Тэгээд Сүнжид доктор бас нэмээд хоёр, гурван үг хэлчих үү?

С.Бямбацогт: Ганбат гишүүн асуултаа асууя.

Д.Ганбат: Хүний эрхийн асуудал бол маш чухал асуудал. Энэ ажлын бараг суурь асуудал. Тэгээд бас энэ хууль маань ээлжит нэг цаас битгий болчоосой. Ингээд батлагдаад гарахаараа зөрчигдөөд байгаа хүний эрхийг яаж дээдлэх ёстой вэ, тэр хэмжээнд нь байлгах тэр тал дээр байж чадах уу? Бид бүхэн холоос юм хайгаад яах вэ. Нэг холын жишээ, ойрын жишээ би нэг ярьчихъя. Саяхан гэхэд 58 настай, Улаанбаатар хотын иргэн Архангайгаас ирэхдээ приус машинд дөрвүүлээ, нэг жирэмсэн эмэгтэй, 1 настай хүүхэд, ингээд дөрвүүлээ ирээд, Монгол Улсын Үндсэн хуульд эрүүл мэндийн яаралтай тусlamж үнэ төлбөргүй авна гэсэн 16.1-д заасан заалтаа зөрчүүлсэн. Тэгээд энэ хүн маань амь наасаа алдсан. Яг Улаанбаатар хотын 22-ын товчоон дээр шүү. Энэ талаар одоо хэн нэгэн ярих юм болов уу гээд хүлээгээд хараад байлаа. Хэн ч ярихгүй байна. Засаг төр нь бол анх удаагаа Ерөнхий сайд миний жишгээр уучлалт гүйх шиг боллоо. Улсын онцгой комиссын дарга нь ингээд уучлалт гүйх шиг боллоо. Ингээд л өнгөрч байгаа юм уу? Хоёр хүүхэд цаана нь өнчин үлдэж байна. Иймэрхүү байдалтай эрх нь зөрчигдэж байгаа улсын энэ нөхцөл байдал дээрдэх юм уу? Эсхүл бас сүүлийн үед энэ залуу дарга нар дотроос, сайд нар дотроос ээлжит нэг нөхцөл байдал, гадагшаа олон улсын байгууллагад бид нар ингэж харагдахын тулд ийм баймаар байна, тийм баймаар байна гэсэн тийм юмны бас нэг золиос болох юм биш биз?

Тэгээд цааш нь үргэлжлүүлээд ярихад 2008 оны 7 сарын 1-нийг бид нар эргэж саная. Тэгэхэд Монгол Улсын таван иргэн зүгээр Сүхбаатарын талбайд хар хувцастай хүмүүс маск зүүгээд, араас нь элдээд ингээд буудаж алсан. Энэний хариуцлагыг хүлээсэн хүн байхгүй ээ. Бүр урагшлуулаад ярих юм бол 700 сүм хийд нураасан, 30, 40 мянган Монгол Улсын иргэд үрэгдсэн. Энэ талаар одоо хэн ч ярьдаггүй болжээ. Нөгөө нам нь байгаад байдаг. Гэхдээ тухайн үедээ ийм үйлс хийж байсан намуудыг үйл ажиллагаа явах эрхийг нь хүртэл хааж байсан, болиулж байсан. Энэ эрхийг хүн биш, бас нам зөрчдөг, засаг төр нь зөрчдөг. Хамгийн том зөрчил хийдэг, хүний эрхийг байхгүй болгодог байгууллага чинь эд нар шүү дээ. Энэ дээр энэний төлөө тэмцсэн хамгаалагчдыг яаж хамгаалах юм бэ? Энэ дээр заасан заалт байна уу? Тэгэхгүй бол бас нэг ээлжит нэг цаас нэмчихсэн. Тэгээд гадагшаа, дотогшоо болохоор бид нар ийм сайхан хуультай, ингэж байгуулдаг ийм сайхан хүмүүстэй гээд хэдэн хүмүүс заачихдаг. Энэ хүмүүс нь болохоор амьдрал дээр яг тэр тэнгэр хол, газар хатуу байгаа хүмүүс дээр очдоггүй. Бид ч гэсэн энэ дотор бас сайхан сайхан юм яриад сууж байдаг. Амьдрал дээр болохоор байхгүй болчихдог ийм юм байж болохгүй л гэж хэлэх гээд байгаа юм.

Бид нар, Хууль зүйн байнгын хороо энийг хэлэлцээд Улсын Их Хурлын чуулганаар батлаад явчихдаг. Их л том ажил хийчихсэн юм шиг үлддэг. Бас л ингээд өмнө нь зөрчигдсэн, одоо зөрчигдөх, цаашид зөрчүүлэх ийм хүмүүс дээр.

С.Бямбацогт: Цогтбаатар гишүүн хариулья.

Д.Цогтбаатар: Яг саяын таны асуусан асуултын л хариулт энэ хууль байгаа юм л даа. Хатуу байж чадах уу гээд. Тэр хүмүүсийнх нь эрхийг хамгаалж өгөөгүй, нэг үг дуугарсныхаа дараа яаж ч шоглуулж магадгүй ийм шоглоомтой орчинд байгаа байхгүй юу. Энэ бодит Монголын үнэн шүү. Тэгэхэд энэ дээр тэр хамгаалалт байхгүй цагт хамгаалаагүй байж, оролдчихож магадгүй тэр институц чинь өнөөдөр энэ Монголын төр өөрөө байхгүй юу. Тэгээд өөрөө өөдөөс нь хараад өөрөө хамгаалаагүй, чи дуугарч чадах уу миний эсрэг гээд чадахгүй. Тэгэхээр энэ шинэ хамгаалах институц чинь орж ирэх ёстой байгаад байгаа юм.

Яг таны саяын хэлсэн дээр энэ приус машины тохиолдол байна, энд хүн амь нас эрсэдсэн. Нөгөө талд тэгээд хүн дуугарахгүй байгаа биз? Одоо Болроо гээд нэг охин гадаа гарч ирээд л зогссон, хөгжлийн бэрхшээлтэй. Нөхөр нь үнэхээр ямар ч төрийн байгууллагууд үл тоомсорлож, тэр охиныг ямар ч байдлаар хүлээж авахгүй ийм байгаад байсан үе. Тэгээд заавал хүний эрхийн асуудал Монгол Улсын Ерөнхий сайдын түвшин дээр очиж шийдэгдэг байж болохгүй ээ. Харин энэ Ерөнхий сайд чинь өөрөө анхаараад энэ дээр анхаарч гарч ирээд энэ Болроо дээр ч гэсэн анхаараад, энэ приус дээр ч гэсэн Монголын төр ингэж болохгүй гээд байр сууриа илэрхийлээд байна. Тэгтэл, энэ чинь Ерөнхий сайд бүх юманд угаасаа хүрч чадахгүй шүү дээ. Тэр Ерөнхий сайдгүйгээр Монгол Улсын хүний эрхийг хамгаалах институц өөрөө бүрэн хүчин чадлаараа ажиллаад явж байх ёстой. Наадуулд чинь тэр гар, хөл дутаад байгаа учраас доороосоо өөрсдөө санаачлаад оруулж ирж байгаа юм. Түүнээс дээрээс аль нэг дарга энийг хийгээд байгаа юм биш ээ.

Гадаадынханд гоё харагдах шаардлага ерөөсөө байхгүй. Бид өөрөө өөрийнхөө тухай, өөрөө өөрийнхөө төлөө энийг хийж байгаа юм. Энийг дэлхийн 40 орон яагаад бүгдээрээ бас тэр Омбудсмен өөр өөрийн институцтэй. Гэхдээ тэнд хаягдсан орон зай байгаад байна, хаягдсан иргэд байгаад байна гээд. Энийг хараад л яг энэ дээр ээ хуулийг батаж оруулж ирж байгаа юм. Тэгээд

саяын таны хэлж байгаа дээр цаашид зөндөө хүмүүсийн эрх зөрчигдөх эрсдэл байгаад байгаа юм. Яагаад гэвэл төр гэж л байгаа бол хүний эрхэнд эрсдэл байнга байж байгаа юм. Тэрэн дээр ингээд сэтгэл. Бид нарын хамгийн аюултай юм бол бид нар сэтгэл ханачихсан байгаад байна. Монгол Улс бүх юм нь байж байгаа юм чинь болж байна гээд. Бүх юм байгаад ажиллахгүй л байгаа шүү дээ. Тэгээд л бид нар Үндсэн хуулиа өөрчлөө биз дээ? Яагаад гэвэл Үндсэн хууль байсан, гэхдээ ажиллаж өгөхгүй л байгаад байна шүү дээ.

Одоо Навчаа гээд энэ дарга бүсгүй сууж байна. 2008 оны 7 сарын 1-ний дараа Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн бий болчихсон байхад би Хүний эрхийн нэгжийг Монгол Улсын Гадаад яаман дээр анх удаа байгуулж өгсөн юм.

С.Бямбацогт: Цогтбаатар гишүүн 1 минут.

Д.Цогтбаатар: Тэгээд энэ нэгжийг би байгуулж өгсөн. Өнөөдөр болтол энэ ажиллаад, одоо ийм хуулиудыг гаднын жишээн дээрээс судлаад оруулж ирэх гол ажлыг эд нар хийгээд л байгаа юм. Тэгэхээр энэ институцлэгдсэн хөгжил гэдэг чинь өөрөө араасаа тэр хоосон үлдээд байгаа орон зайд бөглөж өгч байдаг, тэр нь нэгэнт үүсчихсэн бол зогсохгүй явж байдаг ийм л ач холбогдолтой. Тэгэхээр та нар маань энэ талаас нь хараад дэмжиж өгөөч ээ гэж үнэхээр хүсэж байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Ганбат гишүүн 1 минут.

Д.Ганбат: За, яг миний болгоомжилж байсан тэр тал руугаа л битгий явчихаасай даа. Энэ хууль маань яг эрхээ зөрчүүлээд байгаа тэр хүн рүүгээ л буугаасай даа. Тэгэхгүй, тэр хүний эрхийн зөрчлийг арилгах ёстой, хийх ёстой ажлаа хийгээгүй хүмүүсийг хаацайлан хамгаалах тэр тал руугаа битгий явчихаасай даа. Тухайлбал, сая Ерөнхий сайд, тэр хүн гээд яриад явчихлаа л даа. Яг одоо хэлмэгдэж байх үед тэр албан тушаалтан хaa нэг газар кноп дараад явж байж болохгүй л дээ. Тэгэхээр энэ тал руугаа анхаарах ёстой. Юм бол нөгөө тал руугаа явчихдаг ийм тал бий. Энэ хуулийг жинхэнэ тэр эрхээ зөрчүүлсэн, хүний эрхийг дээшлүүлэх тэр тал руу л явуулахгүй бол нөгөө зөрчдөг хүмүүсийг нь хамгаалах энэ тал руу нь явуулчихаж болохгүй шүү. Тийм магадлал бас байна шүү.

С.Бямбацогт: Цогтбаатар гишүүн нэмэлт хариулт.

Д.Цогтбаатар: Би тантай санал нэг байгаа байхгүй юу. Сая та миний юуг буруу ойлгочих шиг боллоо. Эсрэгээрээ, заавал Ерөнхий сайд гэсэн тийм хүн дээр очилгүйгээр энэ систем ажиллаад, таны хэлээд байгаа тэр эрх нь зөрчигдөөд байгаа хүмүүс дээр дарга цэрэггүйгээр өөрөө хамгаалагдаад явдаг энэ механизмыг л бий болгох гээд байгаа байхгүй юу. Тэр утгаар нь хэлээд байгаа юм.

С.Бямбацогт: Би бас нэг асуулт асуучихъя. Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн сая сар гаруйхны өмнө томилогдоод ажилдаа орсон Сүнжид гишүүн сууж байна, энд. Энэ хуулийг бас боловсруулахад Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг Сүнжид гишүүн боловсруулахад манай Цогтбаатар гишүүнд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлсэн байна, тийм үү? Тэгээд тэр үеийн нөхцөл байдал, өнөөдрийн нөхцөл байдал хоёр хоёр өөр болчоод байна л даа. Энэ хууль бол Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээс харахад 2019 оны 2 сард Засгийн газрын хуралдаанаар орсон буюу үндсэндээ 2018 оны нөхцөл байдал дээр санаачлагдаж, боловсруулагдаж Их Хуралд өргөн баригдсан юм байна.

Тэгвэл 2020 оны 1 сард бид нар Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль баталсан. Энэ хууль батлагдсанаар хүчин төгөлдөр болоод таван гишүүнтэй болоод ажиллаж байгаа. Үндсэндээ Хүний эрхийн Үндэсний Комисс маань илүү бүрэн эрх нь нэмэгдсэн. Бүрэн эрх гэдгийн цаад талд эрх байгаа, нэг талаасаа. Нөгөө талаасаа үүрэг байж байгаа. Илүү өргөн цар хүрээтэй үйл ажиллагаа явуулах бололцоо, боломжтой болсон. Өөрөөр хэлбэл, урьд нь Хүний эрхийн Үндэсний Комиссыг шүдгүй арслан байдаг, хазах шүдгүй, мөргөх эвэргүй гэж үздэг байсан бол энэ төрийн өндөр албан тушаалтнууд болж, эрх үүрэг нь нэмэгдээд үндсэндээ бүрэн эрхээ хэрэгжүүлэх бүрэн бололцоотой, хүний эрхийг хамгаалах бүрэн бололцоотой болсон гэж үзэж байгаа юм.

Одоо тэгтэл зэрэгцээд дахиад нэг байгууллага байгуулаад улсын төсвөөс санхүүжүүлээд Хүний эрхийн Үндэсний Комисстай эрхээ булаацалдаад, сая Алтанхуяг гишүүний хэлдгээр тэнгэрт хоёр нар болоод хоорондоо зөрчилдөөд эхлэх юм биш байгаа? Тэр үеийн нөхцөл байдал өөрчлөгдсөн, Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуультай болсон. Хуульгүй байхад энэ хууль санаачлагджээ. Одоо тэгвэл зайлшгүй хэрэгтэй юм уу, хэрэггүй юм уу? Тэр үед Сүнжид бол Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн биш байсан. Хууль судлаач багш байсан. Тэр үедээ зайлшгүй онгорхой цоорхойг олж харж Цогтбаатар гишүүнтэй хамтарч хууль санаачилсан байх. Одоо Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн болсон, үйл ажиллагаа явуулж байгаа юм. Энийг нэг хариулж өгөөч. Энэ зөрчилдөх үү, давхцах уу? Эрх үргээ булаацалдах уу? Зайлшгүй шаардлагатай юу?

Хоёрдугаарт нь, сая бид нар бас яриад байна хүний эрхийн асуудал. Хүний эрх гэдгийн цаад талд чинь нэг хүний эрх нөгөө хүнийхээ эрхийг зөрчихгүй байхаар хязгаарлагдах ёстой шүү дээ. Хүнийг гүтгэдэг, гутаадаг, доромжилдог энэ хүний эрх үү? Энийг та нэг хариулж өгмөөр байна. Тэр чинь гүтгүүлж байгаа хүний эрх байж байгаа, доромжуулж байгаа хүний эрх бас хамгаалагдах ёстой. Хэдхэн жилийн өмнө, та бүхэн мэдэж байгаа шүү дээ. Нэг төрийн албан хаагч эмэгтэй ДОХ-той гэж хэвлэлээр гүтгүүлсэн, түүнээсээ болоод сэтгэл санаагаар унаад хямраад амиа хорлож байсан тохиолдол гарч байсан. Энэ хүний эрхийг хэн хамгаалах ёстой юм бэ тэгвэл?

Нөгөө талдаа итгэл үнэмшлээ, үзэл бодлоо илэрхийлсний төлөө, шүүмжлүүлсний төлөө хүн хариуцлага хүлээж болохгүй. Энийг хэрхэн яаж зааглаж ялгах ёстой юм бэ? Энэ дээр Хүний эрхийн Үндэсний Комисс яаж анхаарч ажиллаж байгаа вэ? Ингэхгүй, гүтгэчхээд, гутаачхаад, доромжилчхоод би эрхээ эдэлсэн чинь намайг ингээчихлээ гэж ярьдаг эсхүл нөгөө талд нь итгэл үнэмшлээ, үзэл бодлоо илэрхийлснийх нь төлөө, шүүмжилснийх нь төлөө хариуцлага хүлээлгэх гээд бичээд байж болохгүй бас. Гэхдээ энд зааг ялгаа бас байх ёстой. Энэ дээр Хүний эрхийн Үндэсний Комисс юу гэж үзэж байна вэ?

1 дүгээр микрофон.

Д.Сүнжид: Бямбацогт гишүүний асуултад хариульяа. Өмнө нь бас гишүүдийн дурдаад байгаа нэг зүйл дээр санал нийлнэ. Тэр нь бусад хуультай буюу Төрийн бус байгууллагын тухай хууль, Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль, гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль гээд бусад хуультай хэрхэн уялдах вэ, Шүгэл үлээгчийн тухай хуулийн төсөл санаачлах эсэх, дэмжих эсэхээс хамаараад түүнтэй бас энэ харилцааг яаж зохицуулах вэ гэдгийг нарийвчилж сайтар үзэх ёстой. Тэгэхээр эхний асуулт Хүний эрхийн Үндэсний Комиссын чиг үүрэгтэй давхцах уу гэж. Үгүй ээ, энэ дээр нэг зүйл байгаа юм. Хүний эрхийн Үндэсний

Комисс дээр шинэ хууль батлагдсан, хүчин төгөлдөр үйлчилж байгаа, таван гишүүнтэй болсон. Тодорхой эрх хэмжээг нэмэгдүүлсэн. Гэвч нэг зүйлийг бид нар бас энэ явцдаа бүгдээрээ Хууль зүйн байнгын хороогоор орж байхад бүгдээрээ хүлээн зөвшөөрсөн. Тэр нь Үндсэн хуульд заасан Монгол Улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөө баталгаатай, 100 хувь хэрэгждэггүй, дандаа хүний эрх бол өөрөө хангах ёстой үйл явц учраас туйлын зорилгодоо хүрнэ гэж байдаггүй. Энд бид нар байнга төрийн байгууллагуудаас болоод иргэний нийгмийн байгууллагууд, иргэд бүгдээрээ хүчин чармайлтаа гаргаж хүний эрхийг хамгаалах ёстой, шаардлагатай гэдэг дээр санал нэгддэг. Тэгэхээр одоо энэ байгууллагын хувьд үндэсний тогтолцооны хувьд бүх төрийн байгууллагууд хүний эрхийг хамгаалах үүрэгтэй. Үндсэн хуулийн 19.1-ээрээ хүний эрхийг хамгаалах эдийн засаг, хууль зүй, нийгмийн баталгааг нь хангах, хэрвээ зөрчигдвэл түүнийг нь эрхийг нь сэргээх энэ үүргийг төр өөрөө хүлээдэг. Тэр гэдэг нь хууль тогтоох байгууллага, гүйцэтгэх эрх мэдлийн бүх байгууллага, шүүх, хууль, хяналтын байгууллага, Хүний эрхийн Үндэсний Комисс бүгдээрээ хүлээж байгаа.

Энэ тогтолцоон дунд ажиллаж байгаа боловч бид нар ахицтай алхам, прогресс байгаа хэдий ч хүний эрхийн зөрчил бол тасрахгүй байсаар байна. Тэгээд 2020 оны үйл явдал бид нарт дахиад шинэ сорилыг үзүүлж байгаа нь юу вэ гэхээр хөл хорио, бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдал, бүх нийтийн бэлэн байдлын үед хүний эрхийн зарим зөрчил зарим бүлгийн эрх бол ноцтой зөрчигддэг юм байна. Анхаарал тавих ёстой. Түүн рүү нэн тэргүүнд хариу арга хэмжээ авах ёстой, шийдвэр гаргахыг шаарддаг юм байна. Энэний жишээ бол бид нар сая сүүлийн бүх нийтийн бэлэн байдлын үед бүгдээрээ харсан. Зарим нэг хэсэг бүлгүүд, зорилтот бүлгүүд, зарим нэг газар амьдарч байгаа оршин суугчид, эд нарын эрхийг бид нар тухайллан авах ёстой юм байна. Энгийн үеүдээс өөр юм байна. Тэгэхээр энэ юуг.

С.Бямбацогт: Энэ хуультай холбож ярьж байна шүү дээ, би. Нөхцөл байдал чинь дараа нь аяндаа тайлангаа тавина. Энэ хууль шаардлагатай юу? Давхцах уу, давхцахгүй юу гэж асуусан. Асуултад тодорхой хариулья.

Д.Сүнжид: Тэгэхээр таны нэгдүгээр асуултад хариулахад Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуультай чиг үүрэг нь давхцахгүй. Энэ тогтолцоо бий болсноороо чиг үүргийн давхцал үүсэхгүй, бие биенээ нөхөөд дэмжээд үйл ажиллагаагаа гүйцэтгэх боломжтой.

Хоёрдугаар асуултын хувьд хууль бүх эрхүүдийг нэг эрх нөгөөгөөр хязгаарлагддаг. Энэ дээр бид нар хуулиар зохицуулдаг. Нарийвчилсан салбарын хуулиар зохицуулдаг. Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, итгэл үнэмшилтэй байх эрхийг бид нар бас Үндсэн хууль дээрээ хэлсэн байгаа. Итгэл үнэмшилтэй байх эрх бол өөрөө 19.2 дээр онц болоод дайны байдлын үед ч гэсэн хязгаарлаж болохгүй эрхийн тоонд ордог. Тэгэхээр энэ дээр бид нар нухацтай хандах ёстой. Тэгээд энэ итгэл үнэмшилтэй байх, үг хэлэх эрх чөлөөг хэрвээ хязгаарлах гэж байгаа бол, тэрэн дээр итгэл үнэмшилтэй байхыг хязгаарлаж угаасаа болохгүй тийм ээ. Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх дээр тодорхой хязгаарлалт хийх гэж байгаа бол тэрэн дээр хууль ёсны хувьд тавигддаг зарчмууд зорилгодоо хүрээд байгаа юм уу, бусдыг гүтгэсэн, доромжилсон уу, тэр тэнцвэр зайлшгүй юу гэдэг тэр хязгаарлалтын асуудлыг нь заавал тусгах ёстой. Мөн Эрүүгийн хуулиар заавал шийтгэх ёстой юу, үгүй юу? Энэ өөр бусад байдлаар тэр эрхийг эргэж сэргээх асуудал яригдах уу гэдгийг зайлшгүй авч үзэх ёстой.

Ахиад нэг зүйлийг нэмж хэлэхэд хувийн халдашгүй байдлын асуудал Хүний эрхийн Үндэсний Комисс руу байнга ирж байгаа. QR код, иргэний үнэмлэхийн код, энэ царай таних технологи нь өөрөө хувийн халдашгүй байдлыг хангах уу гэж. Энэ дээр тусгайлсан хууль хэрэгтэй. Энийг бид нар бас хэдийгээр хөл хорионы бүх нийтийн бэлэн байдлын үед зайлшгүй гэж үзэж байгаа түр хугацааны арга хэмжээ байж болох боловч цаашдаа бид нар энэ дээр заавал хууль зүйн үндэслэлийг нь хэлээд ямар зорилгоор цуглуулах вэ хувийн мэдээллийг.

С.Бямбацогт: Цогтбаатар гишүүн нэмж хариульяа.

Д.Цогтбаатар: Бямбацогт дарга маш чухал асуудлыг та яг хөндөж гаргалаа. Ингээд энэ нэрээр бусдын эрхийг харин зөрчөөд хүн гүтгээд янз бүр болоод явах юм биш биз дээ? Одоо тийм тохиолдол үнэхээр Монголд их байгаа шүү дээ. Энэ дээр 7 дугаар зүйл дээр харин энийг бүр тодорхой, хориглоод өгчихсөн. Хувийн эрх ашигтаа хүний эрхийн хамгаалагчийн статусаа ашиглахгүй байх, тэгээд 7.1.3 дээр бүр тэр нэгэн хүний эрхийн хамгаалагч юм чинь нэгдүгээрт, хүний эрх, эрх чөлөөгөө үл хүндэтгэсэн ийм зөрчсөн үйлдэл хийж болохгүй гээд заачихсан байгаа. Өөрөөр хэлбэл, хэн нэгнийг гүтгэж аливаа нэгэн хууль бус тийм үйл ажиллагаа явуулж хэн нэгний нэр хүндэд халдсан бол тэр хүн хамгаалагч гэж энэ хуулийн ард орж өөрийгөө хамгаалах ямар ч боломжгүй. Яагаад гэвэл хориод өгчихсөн байгаа.

Харин манай өнөөдөр хуульд байгаа, яг үнэн шүү дээ. Энийг далимдуулж аягүй олон хүн янз бүрийн юм хийж өөрийнхөө амьжиргааг залгуулж явж байгаа зөндөө хүмүүс байгаа. Тэд нараас чинь ялгаад өгч байгаа байхгүй юу, энэ хууль бол харин. Тэд нар чинь биш шүү, энэ огт өөр хүмүүсийг, субъектыг яриад байна шүү гэдгийг энэ хуулиар нь ялгаж салгаж тодруулж өгч байгаа юм.

С.Бямбацогт: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төсөлтэй холбогдуулж саналаа хэлэх гишүүд байвал нэрсээ өгье. Алтанхуяг гишүүнээр тасаллаа. Дэлгэрсайхан гишүүн үгээ хэлье.

Б.Дэлгэрсайхан: Энэ хуулийг үзэл баримтлалын хувьд бол дэмжиж байна. Одоо бол манайд нэг ийм сонин гаж тогтолцоо бий болчоод байгаа юм. Бүх хүн эрх ярьдаг. Үүрэг ярьдаг хүн нэг ч хүн байхгүй болсон. Тийм учраас энэ хуульд байгаа үүрэг, иргэн хүн ямар үүрэг хүлээх юм бэ? Тухайлбал, энэ хууль дээр байгаагаар бол хоёр хүн хүний эрх хамгаалах төрийн бус байгуулах гээд олон зүйл, заалт байна л даа. Тэгэхээр энийг эсрэгээр нь ашиглаад гэдэг юм уу, мэдээж хүний эрх хамгаалах ажил бол төрийн ч үүрэг, иргэний ч үүрэг, гэр бүлийн ч үүрэг гэж ойлгож байгаа юм.

Сүүлийн үед сошиалаар үгээ хэлэх эрхтэй, үгээ хэлэх эрхийг нь хязгаарлахгүй, үзэл бодлоо хэлэх эрхийг нь хязгаарлахгүй гээд. Тэгээд үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх гэдэг нэрийн дор хүн доромжлох, гүтгэх ийм явдал газар авсан шүү дээ. Одоо хэн дуртай нь лайв хийгээд гэдэг юм уу, сүүлийн үед бол техник технологи их хөгжчихсөн, дуртай газраасаа юу ч хамаагүй ярьж болдог. Тэрийгээ би бусдын эрхийг хамгаалж байна, эсхүл гэмт хэрэг илрүүлж байна гээд ингээд их мундаг юм яриад байгаа юм. Тэгээд эцсийн эцэст энийгээ нотолж байгаа хэн ч байхгүй. Тийм учраас энэ хүний эрх, эрх чөлөө ярихдаа бол миний ойлгож байгаагаар бас Эрүүгийн хуультай холбож энийгээ ярих ёстой юм уу гэж ойлгож байгаа юм. Тэгэхгүй, одоо дахин хэлэхэд хүн болгон эрх яриад байгаа мөртлөө үүргээ ерөөсөө ярихгүй, түрүүн Бямбацогт даргын хэлдгээр бол өөрийн эрх бол бусдын эрхээр хязгаарлагдана гэж. Тэрийгээ ойлгож байгаа хүн хэд байдаг юм

бэ? Энийг энэ хуульд яаж тусгах вэ, дараа нь хариуцлага байгаа юу? Зөвхөн эрх, үүрэг гээд заачихдаг. Санкц байхгүй.

Эрүүгийн хуулиас гадна энэ олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглаж, шинжлэх ухаан, техникийн ололтыг ашиглаж бусдыг үг хэлээр доромжлох, үндэслэлгүйгээр гүтгэх зэргээ өөр арга замаар, олон нийтийн байгууллагын арга замаар яаж хязгаарлах вэ? Эсхүл сошиал, шинжлэх ухаан, технологи хөгжиж байгаатай холбогдуулан техник талаас нь хязгаарлах ч байдаг юмуу, ийм юмнуудаа яаж хийх вэ гэдэг асуудал их чухал болчоод байгаа юм л даа. Мэдээж хүн болгон өөр өөр үзэл бодолтой гэдгийг бол ойлгож байгаа юм. Тэгэхдээ энийг чинь хязгаарлаж өгөх юм нь хууль шүү дээ. Тэгээд хууль нь байхгүй болохоор хуульдаа ямар нэгэн заалт оруулаад, энийг чинь хязгаарлай гэхээр л, тэр хүний үзэл бодлоо илэрхийлэх, эрх чөлөөгөө илэрхийлэх энэ боломжийг хааж байна гээд байгаа юм. Манайд бол эрх чөлөө багадаагүй шүү дээ. Хүн болгон л энийг яривал таалагдана гэж ойлгоод байх шиг байгаа юм.

Үүрэг л ер нь дутаад байгаа шүү дээ. Хүмүүс ер нь өөр өөрийнхөө үүргийг хувь хүнийхээ үүргийг гүйцэтгэх явдал бол бүр байхгүй болсон шүү дээ. Жишээлбэл, хамгийн наад зах нь бүгдээрээ мэдэж байгаа. Хүний эрхийн Комиссын гишүүн байгаа дээр би нэг юм асуух байсан. Тэгээд зүгээр саналаа хэлье. Жишээлбэл, хүүхдийнхээ тэтгэврийг төлдөг ийм эцэг, эх байна уу? Шүүхийн шийдвэрээр гарсан тоо баримтаар бол 23 мянган хүн энэнээс зугтаж байгаа шүү дээ. Тэгээд үүргийн тухай нэг ч яриа байхгүй. Тэгээд дандаа нэг ийм попрох, тэнд ганц нэг хүн тусламж авч чадаагүй ийм юман дээр улс төр хийх ийм юм чинь одоо энэ Монголын нийгмийг талцуулдаг юм уу, энүүгээрээ амьдардаг, түрүүн Цогтбаатар гишүүний хэлдгээр энийгээ хоол олж идэх хэрэгсэл болгож байгаа байхгүй юу, сүүлийн үед бол. Бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ. Энэ ямар нэгэн байдлаар сошиалаар.

С.Бямбацогт: Дэлгэрсайхан гишүүн 1 минут.

Б.Дэлгэрсайхан: Сүүлийн үед эх оронч дүр эсгэдэг, олон нийтийн төлөө явж байгаа гэдэг хүмүүсийн цаана бол Баабар гуйайн хэлдгээр бол өчүүхэн жижиг өөрийнх нь эрх ашиг байдаг юм гэж. Би бол яг л энээнтэй санал нэг байгаа юм. Явж явж эцсийн үр дүн нь жижигхэн, өөрийнх нь эрх ашиг амьдрах эх сурвалж нь болж, ийм байдалд оччихсон. Энийгээ яаж хаах юм бэ? Заавал тэрийг Эрүүгийн хуулиар биш, торгууль янз бүрийн юмаар биш, энийгээ ер нь яаж хаах юм бэ? Технологийн дэвшлээр нь буцааж хаах юм уу? Эсхүл тэр хүнийг хүн доромжилсных нь төлөө үг хэлэх, сошиалаар технологийн дэвшлээр хааж өгдөг ч юм уу, эсхүл нүүрээ гаргаж байгаад ил яриад, тэрнийхээ төлөө хариуцлага хүлээдэг ч юм уу. Ийм байхгүй бол нүүрээ.

С.Бямбацогт: Дэлгэрсайхан гишүүн саналаа хэллээ. Одоо Сандаг-Очир гишүүн саналаа хэлье.

Ц.Сандаг-Очир: Энэ хуулийг зарчмын хувьд дэмжиж байгаа. Монгол Улс үнэхээр л ардчилсан, хувь хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн улс орон юм бол хүний эрхийн төлөө дуугардаг, хамгаалдаг, тэмцдэг ийм хүмүүсийг. Харин энэ дээр өнөөдөр манай Монголын нийгэмд буруугаар тогтчихоод байгаа хандлага бол хүний эрхийн улс төрийн эрхтэй холбогдуулсан, дуугарсан, хэвлэн нийтэлсэн энэ талаар энэ хамгаалагчийг л хүний эрхийн хамгаалагч гэж ойлгодог болсон. Энэ хандлагыг бас энэ хуулиар өөрчилж, ер нь хүн болгон хүний эрхийн хамгаалагч юм байна гэдэг, байгууллага болгон хамгаалагч юм байна гэдгийг ойлгуулсан энэ

хандлагыг тогтоох, ойлгуулахад бас анхаарал хандуулах ёстой гэж би хувьдаа үзэж байгаа юм.

Тэрнээс биш улс төрийн эрх чөлөөгөө л эдэлсэн, цаанаа ямар нэг зорилго, агуулгатай, хэн нэгний өмнө дохиураар явдаг энэ эрх, эрх чөлөөгөө эдэлж байна гэж ингэж олон нийтэд хүний эрхийн хамгаалагч болдог. Энэнээс ялгах, салгах. Үнэхээр хөдөлмөрийн талбар дээр, байгууллага дээр хүний эрүүл мэндийн төлөө, байгууллага, хамт олны төсөв санхүүгийн эрх мэдлийн төлөө ч гэдэг юм уу, яг хүний эрх, эрх чөлөөтэй ажлын байрны дарамтын эсрэг ч гэдэг юм уу ингэж дуугарч байгаа, энэ бол хүний эрхийн хамгаалагч юм гэдэг ойлголт хандлага бол бага байгаа, сул байгаа шүү. Харин гаргууд сайн хөгжсөн нь бол улс төрийн эрх чөлөө. Талбай дээр жагсахаараа хүний эрхийн хамгаалагч болдог ийм л ойлголт, хандлага өнөөдөр Монголын нийгэмд буй болсон.

Тийм учраас энэ хуульд бол үнэхээр цаашид энэ шинээр байгуулагдах хороо нь энэ ажлаа, хүний эрхийг Хүний эрхийн комисс л хангадаг гэдэг ийм ойлголт бас Монголын нийгэмд тогтсон. Тэрнээс бүх л юмыг Хүний эрхийн комисс руу хандаж хийдэг. Хүний эрхийн комисс л хөдлөхгүй байна, дуугарахгүй байна, миний эрх, эрх чөлөөний төлөө гэж ийм хандлага байгаа учраас энэ шинээр байгуулагдах хороо бол бүх иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болгон хүний эрхийн төлөө дуугардаг, тэмцдэг хамгаалагч нь юм гэдэг энэ ойлголт, хандлагыг төлөвшүүлэх нь энэ хуулийн гол үзэл санаа юм болов уу гэж би хувьдаа ойлгож байгаа учраас энэ хуулийг зарчмын хувьд дэмжиж байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Алтанхуяг гишүүн саналаа хэлье.

Н.Алтанхуяг: Би хүний эрхийн төлөө бол тууштай тэмцэнэ. Тэмцэж ч яваа. Тэгэхдээ энэ хуулийг яг энэ бичсэн бичлэлээр нь би дэмжиж чадахгүй ээ. 6.1.5 дээр “хүний эрхийг хүндэтгэн хамгаалах зорилгоор үндэсний болон олон улсын санхүүгийн нөөц, эх үүсвэрийг хайх, хүлээн авах, захиран зарцуулах. Гадаадаас мөнгө авч хүний эрхийг хамгаалж болохгүй.” Тэгээд энэ хороо даргатай байна, зургаан гишүүнтэй байна, гишүүнд дараах шаардлага хангасан хүний нэр дэвшүүлнэ гээд. Энэ бол яг энэ бичлэлээрээ бол бид нарт хүний эрхийг хангахад нэг их дэм болохгүй ээ.

Би хоёр дахь асуудал хэлье. Дэлгэрсайхан гишүүн ч хөндөөд байна, Энхбаяр гишүүн ч яриад байна. Намайг Ерөнхий сайд байхад Тэмүүжин сайдын оруулж ирсэн хуулийн төсөл дээр “үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлсний төлөө шоронд орж болохгүй” гэдэг иймүүс төрийн шийдэлтэй хуулийг баталсан юм. Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлсний төлөө Монгол Улсын нэг ч иргэнийг шоронд хорьж болохгүй. Энэ нь эрүүгийн хэрэг биш гэж үзнэ. Тэгэхээр яадаг вэ, чамайг дураараа доромжлоод байж болдог юм уу гэвэл болдоггүй юм. Тэрийг чинь Зөрчлийн хуульд аваачиж хийгээд, та нар гутгүүлж үзээгүй юм уу? Би бол зөндөө гутгүүлсэн хүн. Тэр хуулийн дараа тэр хуулийг чинь хэрэглэж үзсэн. Хорооны цагдаа дээр өгчихдөг юм байна лээ. Зөрчлийн хууль. Би өргөдлөө гаргаад Зөрчлийн хуулиар хорооны цагдаад өгдөг юм. Харин би тэрийг жаахан дээшлүүлмээр санагдаад байгаа юм. Хорооны цагдаа жаахан авч, дуудаж намайг асуугаад, нөгөө талыг нь нэг асууснаа “хаалаа, хэрэг үүсгэхээс татгалзлаа” гээд. Би болохгүй юмаа бас ярьж байна шүү. Энийгээ янзлах юм байна лээ. Тэгэхээр нь шүүх чинь бас судалж үзэж байна гээд хоёр талыг баахан материал цуглуулаад ингээд явдаг юм. Шүүхэд өгч үзсэн. Шүүх бол гайгүй явдаг юм байна лээ шүү.

Тэгээд эрхэм гишүүд ээ, улс төрийнхөө сонголтыг хий. Битгий эргэлзэж тээнэгэлзээд бай. Үгээ хэлсэн, үзэл бодлоо илэрхийлсэн хэнбулагайг ч гэсэн юу ч гэж хэлсэн шоронд л оруулж болохгүй. Торгууль, янз бүрийн ялаараа шийд гээд намайг Ерөнхий сайд байхад Тэмүүжин сайдыг Хууль зүйн сайд байхад гаргасан хууль явж байгаа. Хэзээ батлагдсаныг би мартчихаж, манай дараа ч батлагдсан байж магадгүй. Би энэ концепц, энэ үзэл баримтлал дээр тууштай байгаа. Хэдийгээр намайг Ерөнхий сайд, янз бүрийн юм болоод намайг гутгэж, гутаадаг байсан боловч би хүний эрх, эрх чөлөө, уг хэлэх, хамгийн гол нь үзэл бодол байхгүй юу. Үзэл бодлоо илэрхийлж байгаа энэ эрхийг бид хааж болохгүй.

Үнэхээр заримдаа уур хүрмээр, дургүй хүрмээр юм зөндөө бичдэг. Тэрийг чинь шийд гээд байна шүү дээ. Цагдаад өг, шүүхэд өг. Шоронд хийж болохгүй. Би бол үхэн үхтлээ энд нэг юм ойлгосон юм бол дарга нар бол үгэнд ор гэж хэлдэг. Жишээ нь миний дээр ганцхан дарга байсан, тэр нь Ерөнхийлөгч. Тэгэхгүй бол яадаг юм бэ гэхээр чамайг шоронд хийнэ гэдэг ийм нийгмийн төлөө явагүй. Ардчилсан нийгэм гэдэг бол ийм юмыг хэлдэггүй. Бид нар ядаж энэ ардчилсан нийгмийнхээ тэр тулгуур зарчмыг авч үлдье. Хүний эрх, эрх чөлөө, үзэл бодол, тэрийгээ илэрхийлэх тэр эрх чөлөөг авч үлдье. Тэгэхдээ зүгээр хая гэсэн уг биш шүү дээ, хэлчихээд байна шүү дээ. Ийм улс төрийн том сонголт хийчихсэн явж байгаа шүү.

Тэгээд танай тэр сайд чинь их сонин юм ярих юм. Тэгээд баахан сошиалаар жинхэнэ бужигнаан үүсгэх юм. Төдөн жилээр шийтгэнэ, шоронд хийнэ. Тэгээд сая энэ Энхбаяр гишүүний хэлж байгааг сонсохоор танай бүлэг дээр тийм юм яриагүй бололтой юм. Тэгээд яах гэж ийм юм ярьж улс орон даяар хүмүүсийг үймүүлж бужигнуулаад байдаг юм бэ? Энэ харилцааг чинь зохицуулчихсан хууль байгаа. Энийгээ өөрчлөх гэж байгаа бол Ардын намынхан, тэр хүмүүс нь гарч ирээд энийгээ хэлээд өөрчлөх гээд үзээрэй. Би бол энэний чинь эсрэг шүү. Энэ завсар маш олон хүн ингээд хүнд байдалд орно Дэлгэрсайхан гишүүн ээ. Гүтгүүлнэ, гутуулна, муухайгаар хэлүүлнэ. Ер нь тэгээд дарга болоход бас хааяа нэг тиймэрхүү уг сонсчиход буруу юм байхгүй. Тэр нь тэгэхдээ тэгээд суугаад бай гэсэн уг биш, хууль ёсныхоо юмаар хандаад, ингээд, ингээд хийгээч ээ. Энэ бол хүний, Монгол хүний гээд хэлчихье, хамгийн амин чухал эрх ашиг шүү. Энийг янз бүрийн сошиалыг хянах, Эрүүгийн хууль болгон өөрчилж шоронд хийнэ гэж айлгаж дарамтлах бол манай улсад байж болохгүй ээ.

С.Бямбацогт: Гишүүд асуулт асууж, уг хэлж дууслаа. Одоо хуулийн төслийг дэмжих эсэхээр санал хураалт явуулна. Түүний өмнө би, хэрэв дэмжигдвэл хэдэн санал хэлэх ёстой гэж бодож байна. Засгийн газраас бас яг энэ хуулийн төслийг тухайн үед бусад нэлээн олон хуультай давхацсан, хоорондоо зөрчилдсэн зохицуулалттай байна гэж санал, дүгнэлтдээ тусгасан байна лээ. Үүнийг бид нар цаашид хэлэлцүүлгийн явцад анхаарч засах шаардлагатай болох байх.

Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийг бид нар баталсан. Энэ хуулиараа Хүний эрхийн Үндэсний Комисст тодорхой бүрэн эрхийг, тодорхой чиг үүргийг нэлээдгүй хэмжээгээр нэмэгдүүлж өгсөн. Одоо Хүний эрхийн Үндэсний Комисс хангалттай ажиллах бололцоо, боломжтой болсон байгаа. Ажлаа сайн хийх ёстой шүү. Дахиад нэг хууль батлаад өгчих, дахиад нэг байгууллага дагуулаад байгуулаад өгчих, тэгэх юм бол бид нар гялалзуулах гээд байна гэдэг асуудал ярихгүй шүү, хүлээж авахгүй шүү. Тайлангаа тавихдаа анхаарна шүү. Тэр яригдаж байна шүү дээ, Ганбат гишүүний ярьж байгаа, Алтанхуяг гишүүний ярьж

байгаа. Тэр хүний эрх хаана зөрчигдөөд байна вэ, хэн зөрчөөд байна вэ тэнд бид нар дуугарч баймаар байна. Ер нь дуу хоолой нь сул байгаад байгаа шүү.

Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд иргэний нийгмийн зөвлөл бас ажиллана гэж тодорхой заасан байж байгаа. Иргэний нийгмийн зөвлөлийн хүрээнд энэ хэлбэрээр ажиллах юм бол энэ асуудлыг дэмжих ёстой гэж би бас үзэж байна. Хүний эрхийн хамгаалагч нь 18 бүрэн эрхтэй байгаа. Сая хэллээ шүү дээ, олон улсын байгууллагаас зээл тусламж аваад түүгээрээ хүний эрхийг хамгаалж болно гээд орчихсон. Дээрээс нь хүний эрхийн хамгаалагч нь зөвлөмж, дүгнэлт гаргана гээд орчихсон. Өөрөөр хэлбэл, сая Сүнжид хэллээ шүү дээ, бараг чиг үүрэг нь давхцахгүй гэж. Үндсэндээ энэ хүний эрхийн хамгаалагчийн ажил Хүний эрхийн Үндэсний Комиссын ажил зэрэгцээд, та наортай зэрэгцээд зөвлөмж гаргаад, дүгнэлт гаргаад ингээд явах л хууль болчихсон байна шүү дээ. Тэр давхцахгүй, чиг үүрэг давхцахгүй гээд хэлээд суугаад байх юм чи.

Дээрээс нь орон тоо, төсөвтэй байна. Орон тоо, төсвийг нь Хүний эрхийн Үндэсний Комиссоос санхүүжүүлнэ гээд орчихсон байна. Тэгсэн мөртлөө Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэд ажиллана гэсэн мөртлөө бие даасан, хараат бусаар ажиллана гээд орчихсон. Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэд мөртлөө бие даасан, хараат бусаар ажиллана гээд иймэрхүү, иймэрхүү олон зөрчилтэй заалтууд байна шүү. Энийг цаашид хэлэлцүүлгийн явцад бид анхаарах ёстой гэдэг өөрийнхөө саналыг хэлье.

Ингээд санал хураалт явуулъя. Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт

Цогтбаатар гишүүн, хууль санаачлагчид микрофон өгье.

Д.Цогтбаатар: Би саналаа дэмжиж өгсөн. Энэ бүртгэсэнгүй. Тийм учраас дэмжсэнд тооцож оруулья.

С.Бямбацогт: Тийм боломжгүй. Дахин санал хураалгах горимын санал гаргая.

Д.Цогтбаатар: Горимын санал гаргая. Саналыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулъя.

С.Бямбацогт: Цогтбаатар гишүүний горимын санал, саяын санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя. Горимын санал.

Цогтбаатар гишүүний гаргасан горимын санал дэмжигдсэн учраас санал хураалтыг дахин явуулъя.

Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 13 гишүүн оролцож, 53.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцээн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Мөнхцэцэг гишүүн танилцуулья.

Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулж дууслаа.

Дараагийн асуудалд оръё.